



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 10 сарын 07 өдөр

Дугаар 8/46

Ховд

Биеийн тамир спортын газрын бүтэц,
орон тоог шинэчлэн батлах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 65 дугаар зүйлийн 65.1.8 дахь заалт, Биеийн тамир, спортын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1, 18 дугаар зүйлийн 18.5 дахь заалт, Засгийн газрын 2024 оны 128 дугаар тогтоол, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 10/06 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Биеийн тамир, спортын газрын бүтэц орон тоог нэгдүгээр хавсралтаар, өсвөр үеийн шигшээ багийн дасгалжуулагчдын орон тоог хоёрдугаар хавсралтаар тус тус шинэчлэн баталсугай.

2. Өсвөрийн шигшээ багийн дасгалжуулагчдыг 8-аас доошгүй төрлөөр спортын холбооны орон нутаг дахь салбартай хамтран сонгон шалгаруулж мэргэжил арга зүйгээр ханган ажиллуулахыг Биеийн тамир, спортын газрын дарга (Ч.Түмэндэмбэрэл), орон нутгийн төсвөөс үзүүлэх санхүүгийн дэмжлэгийг жил бүрийн төсөвт тусгаж ажиллахыг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Ч.Багдал) нарт тус тус үүрэг болгосугай.

3. Хавсралтаар батлагдсан бүтэц орон тоог цалингийн сан, батлагдсан төсөвт багтаан байгууллагын үйл ажиллагааг үр дүнтэй зохион байгуулж ажиллахыг Биеийн тамир, спортын газрын дарга (Ч.Түмэндэмбэрэл)-д үүрэг болгосугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажилахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Б.Сандагсүрэн)-д даалгасугай.

5. Энэ захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2023 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн А/173 дугаар захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГЫН ОРЛОГЧ

Х.БАТБОЛД

8400001-1797

Zah.B/42 Kh

Засаг даргын 2024 оны
10 дугаар сарын 07-ны өдрийн
Б/42 дугаар захирамжийн
хоёрдугаар хавсралт

ӨСВӨР ҮЕИЙН ШИГШЭЭ БАГИЙН ДАСГАЛЖУУЛАГЧИД

Д/д	Албан тушаалын нэр	Орон тоо	Албан тушаалын ангилал, зэрэглэл
1	Үндэсний бөхийн дасгалжуулагч	1	ТҮСБ-4
2	Волейболын дасгалжуулагч	1	ТҮСБ-4
3	Сагсан бөмбөгийн дасгалжуулагч	1	ТҮСБ-4
4	Хөл бөмбөгийн дасгалжуулагч	1	ТҮСБ-4
5	Жүдо, самбо бөхийн дасгалжуулагч	1	ТҮСБ-4
6	Чөлөөт бөхийн дасгалжуулагч	1	ТҮСБ-4
7	Хөнгөн атлетикийн дасгалжуулагч	1	ТҮСБ-4
8	Ширээний теннисний дасгалжуулагч	1	ТҮСБ-4
НИЙТ		8	-

-oOo-

Засаг даргын 2024 оны
10 дугаар сарын 07-ны өдрийн
Б/42 дугаар захирамжийн
нэгдүгээр хавсралт

БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗРЫН БҮТЭЦ ОРОН ТОО

Д/д	Албан тушаалын нэр	Орон тоо	Албан тушаалын ангилал, зэрэглэл
1	Газрын дарга	1	ТЗ
2	Биеийн тамирын хэлтсийн дарга	1	ТЗ
3	Спортын хэлтсийн дарга	1	ТЗ
4	Биеийн тамирын бодлогын хэрэгжилтийн асуудал хариуцсан мэргэжилтэн	1	ТҮСБ
5	Ахмад, хөгжлийн бэрхшээлтэй хүний биеийн тамирын асуудал хариуцсан мэргэжилтэн	1	ТҮСБ
6	Биеийн тамирын арга зүйчийн асуудал хариуцсан мэргэжилтэн	1	ТҮСБ
7	Тогтоол шийдвэр, тайлан мэдээ, хүний нөөц хариуцсан ахлах мэргэжилтэн	1	ТЗ
8	Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод хяналт хариуцсан мэргэжилтэн	1	ТЗ
9	Мэдээллийн цахим сан, статистик хариуцсан мэргэжилтэн	1	ТЗ
10	Спортын сургалт, дасгалжуулалтын хэрэгжилтийн асуудал хариуцсан мэргэжилтэн	1	ТҮСБ
11	Спортын тэмцээн, наадам, спортын холбоодын асуудал хариуцсан мэргэжилтэн	1	ТҮСБ
12	Өсвөрийн шигшээ баг, хүүхдийн спортын асуудал хариуцсан мэргэжилтэн	1	ТҮСБ
13	Нягтлан бодогч	1	ТҮМ
14	Архив, бичиг хэрэг	1	ТҮМ
15	Нярав	1	ТҮ
16	Жолооч	1	ТҮ
17	Цахилгаан, сан техникч	1	ТҮ
18	Жижүүр	4	ТҮ
19	Үйлчлэгч	3	ТҮ
НИЙТ			24

-оОо-

Zah B/42 Kh